



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/241/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Л.Одонтуяа Утас: 325093 Цахим хаяг: odontuyal@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд Error! Bookmark not defined.	
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
НТГ	Нийслэлийн татварын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕГ	Татварын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
АТӨЯХАТ	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СХД	Сонгинохайрхан дүүрэг

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠒᠐2᠖-᠐2-25 № 87
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ОТГОНБААТАР
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж, Нийслэлийн Татварын газраас шилжүүлсэн 35.4 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас 97.0 сая төгрөг нийт 132.4 сая төгрөгийн эх үүсвэрийг татварын орлого бүрдүүлэх үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1126050179

© Цэвэр хуульчид (D) Электрон Гэрээний Системийн Холбоо (eScribers) 2014-2025

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 91.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,988,913.66	66,955,017.22
33	АВЛАГА	726,297.64	832,334.20
335	Бусад авлага	726,297.64	832,334.20
3351	Байгууллагаас авах авлага	726,297.64	832,334.20
35	БАРАА МАТЕРИАЛ	70,262,616.02	66,122,683.02
354	Хангамжийн материал	70,262,616.02	66,122,683.02
35410	Бичиг хэргийн материал	3,398,327.84	3,050,324.84
35420	Аж ахуйн материал	1,243,580.00	1,468,330.00
35470	Бусад хангамжийн материал	65,620,708.18	61,604,028.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,121,784,969.76	1,058,257,175.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,121,784,969.76	1,058,257,175.63
392	Биет хөрөнгө	1,117,572,847.73	1,054,163,614.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	957,952,451.44	957,952,451.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-106,936,913.80	-134,444,941.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,999,000.00	45,356,214.26
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,378,879.94	-35,297,217.74
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	494,243,346.63	477,986,833.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-316,338,023.66	-314,050,485.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,104,679.01	109,004,637.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,072,811.95	-52,343,878.11
393	Биет бус хөрөнгө	4,212,122.03	4,093,561.60
39301	Программ хангамж	957,000.00	957,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-719,877.97	-838,438.40
39303	Бусад биет бус хөрөнгө	3,975,000.00	3,975,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,192,773,883.42	1,125,212,192.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,192,773,883.42	1,125,212,192.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1,192,773,883.42	1,125,212,192.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	655,748,149.40	655,748,149.40
51101	Өмч: - төрийн	655,748,149.40	655,748,149.40
512	Хуримтлагдсан үр дүн	227,055,062.44	159,493,371.87
51210	Өмнөх үеийн үр дүн	119,187,186.04	227,055,062.44
51220	Тайлант үеийн үр дүн	107,867,876.40	-67,561,690.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	309,970,671.58	309,970,671.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,192,773,883.42	1,125,212,192.85

2.2 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,583,161,656.49	3,539,660,714.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	242,092,656.49	83,674,714.43
120	Нийтлэг татварын бус орлого	242,092,656.49	83,674,714.43
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	242,092,656.49	83,674,714.43
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	242,092,656.49	83,674,714.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,341,069,000.00	3,455,986,000.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,037,045,600.00	3,323,529,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,037,045,600.00	3,323,529,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	304,023,400.00	132,456,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	304,023,400.00	132,456,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,475,293,780.09	3,580,137,742.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,475,293,780.09	3,580,137,742.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,337,920,559.91	3,417,239,448.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,588,473,444.38	2,695,602,787.02
210101	Үндсэн цалин	1,327,473,833.10	1,387,267,382.00
210102	Нэмэгдэл	420,847,801.86	470,674,689.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	176,173,582.21	227,826,011.91
210104	Урамшуулал	663,978,227.21	609,834,703.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,193,717.89	365,778,496.75
210201	Тэтгэврийн даатгал	225,833,157.52	250,820,399.26
210202	Тэтгэмжийн даатгал	25,777,023.96	28,783,399.33
210203	ҮОМШ өвчний даатгал	12,851,092.85	14,390,699.66
210204	Ажилгүйдлийн даатгал	12,346,468.66	14,354,099.33
210205	Эрүүл мэндийн даатгал	49,385,974.90	57,429,899.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,186,024.80	25,627,480.20
210301	Гэрэл цахилгаан	6,842,472.55	13,246,283.92
210302	Түлш, халаалт	6,595,867.25	6,561,624.28
210303	Цэвэр, бохир ус	5,747,685.00	5,819,572.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,894,984.85	86,334,681.00
210401	Бичиг хэрэг	38,400,188.10	42,127,603.00
210402	Тээвэр, шатахуун	14,055,000.00	5,700,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	11,159,866.75	8,337,278.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,000.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,535,930.00	28,609,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,592,250.00	5,055,300.00
210601	Багаж, техник хэрэгсэл	0.00	3,620,000.00
210604	Урсгал засвар	1,592,250.00	1,435,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,176,886.00	116,878,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,847,000.00	80,113,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	376,510.00	417,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,276.00	355,728.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,796,400.00	35,935,000.00
210807	Газрын төлбөр	35,700.00	35,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,403,251.99	121,961,825.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,123,130.00	475,000.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	11,500,000.00	689,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	139,780,121.99	120,797,825.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,373,220.18	162,898,293.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,752,000.00	41,135,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	40,475,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	106,752,000.00	660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,621,220.18	121,763,083.47

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,621,220.18	121,763,083.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	107,867,876.40	-40,477,027.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	27,084,662.85
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	0.00	27,084,662.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-27,084,662.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	107,867,876.40	-67,561,690.57

2.3 Аудит хийсэн 2025 оны мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,341,069,000.00	3,455,986,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,341,069,000.00	3,455,986,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,037,045,600.00	3,323,529,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,037,045,600.00	3,323,529,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	304,023,400.00	132,456,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	304,023,400.00	132,456,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,331,070,000.00	3,455,306,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,331,070,000.00	3,455,306,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,193,696,779.82	3,292,407,706.53
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,588,473,444.38	2,695,708,823.58
210101	Үндсэн цалин	1,327,473,833.10	1,386,872,125.56
210102	Нэмэгдэл	420,847,801.86	470,674,689.20
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	176,173,582.21	227,868,011.91
210104	Урамшуулал	663,978,227.21	610,293,996.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,193,717.89	365,778,496.75
210201	Тэтгэврийн даатгал	225,833,157.52	250,820,399.26
210202	Тэтгэмжийн даатгал	25,777,023.96	28,783,399.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,851,092.85	14,390,699.66
210204	Ажилгүйдлийн даатгал	12,346,468.66	14,354,099.33
210205	Эрүүл мэндийн даатгал	49,385,974.90	57,429,899.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,186,024.80	25,627,480.20
210301	Гэрэл, цахилгаан	6,842,472.55	13,246,283.92
210302	Түлш, халаалт	6,595,867.25	6,561,624.28
210303	Цэвэр, бохир ус	5,747,685.00	5,819,572.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,313,506.75	57,339,728.00
210401	Бичиг хэрэг	20,704,890.00	38,597,150.00
210402	Тээвэр, шатахуун	13,300,000.00	5,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,682,866.75	7,982,278.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,000.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,881,750.00	3,500,300.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,383,200.00	5,275,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,620,000.00
210604	Урсгал засвар	3,383,200.00	1,655,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,826,886.00	130,698,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,497,000.00	90,983,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	376,510.00	417,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,276.00	355,728.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,796,400.00	38,885,000.00
210807	Газрын төлбөр	35,700.00	35,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,320,000.00	11,979,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,320,000.00	11,979,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,373,220.18	162,898,293.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,752,000.00	41,135,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	40,475,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	106,752,000.00	660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,621,220.18	121,763,083.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,621,220.18	121,763,083.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,999,000.00	680,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,999,000.00	680,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,999,000.00	680,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,999,000.00	680,000.00
223001	Бусад хөрөнгө	9,999,000.00	680,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,999,000.00	-680,000.00

2.4 Аудит хийсэн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	119,187,186.04	1,084,906,007.02
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	119,187,186.04	1,084,906,007.02
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	107,867,876.40	107,867,876.40
C08	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	227,055,062.44	1,192,773,883.42
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	227,055,062.44	1,192,773,883.42

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	227,055,062.44	1,192,773,883.42
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-67,561,690.57	-67,561,690.57
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	159,493,371.87	1,125,212,192.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,382,395,400.00	3,201,807,916.53	180,587,483.47	94.7%
12	Татварын бус орлого	3,382,395,400.00	3,201,807,916.53	180,587,483.47	94.7%
122	Тусламжийн орлого	3,382,395,400.00	3,201,807,916.53	180,587,483.47	94.7%
122005	Төсвөөс санхүүжих	3,382,395,400.00	3,201,807,916.53	180,587,483.47	94.7%
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,382,395,400.00	3,201,807,916.53	180,587,483.47	94.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,382,395,400.00	3,201,807,916.53	180,587,483.47	94.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,340,468,100.00	3,160,672,706.53	179,795,393.47	94.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,862,530,200.00	2,695,708,823.58	166,821,376.42	94.2%
210101	Үндсэн цалин	1,447,424,200.00	1,386,872,125.56	60,552,074.44	95.8%
210102	Нэмэгдэл	515,436,200.00	470,674,689.20	44,761,510.80	91.3%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	209,950,600.00	227,868,011.91	(17,917,411.91)	108.5%
210104	Урамшуулал	689,719,200.00	610,293,996.91	79,425,203.09	88.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	365,778,500.00	365,778,496.75	3.25	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	250,820,400.00	250,820,399.26	0.74	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	28,783,400.00	28,783,399.33	0.67	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,390,700.00	14,390,699.66	0.34	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	14,354,100.00	14,354,099.33	0.67	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	57,429,900.00	57,429,899.17	0.83	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,583,500.00	25,627,480.20	2,956,019.80	89.7%
210301	Гэрэл, цахилгаан	14,411,500.00	13,246,283.92	1,165,216.08	91.9%
210302	Түлш, халаалт	7,425,200.00	6,561,624.28	863,575.72	88.4%
210303	Цэвэр, бохир ус	6,746,800.00	5,819,572.00	927,228.00	86.3%
2104	Хангамж, бараа материалын зардал	28,520,500.00	22,379,728.00	6,140,772.00	78.5%
210401	Бичиг хэрэг	10,872,200.00	9,237,150.00	1,635,050.00	85.0%
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	700,000.00	-	100.0%

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,367,000.00	7,982,278.00	1,384,722.00	85.2%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,100.00	1,560,000.00	40,100.00	97.5%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,981,200.00	2,900,300.00	3,080,900.00	48.5%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,715,300.00	1,655,300.00	60,000.00	96.5%
210604	Урсгал засвар	1,715,300.00	1,655,300.00	60,000.00	96.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,461,100.00	47,643,878.00	3,817,222.00	92.6%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,484,400.00	46,813,450.00	3,670,950.00	92.7%
210803	Даатгалын үйлчилгээ	497,700.00	417,000.00	80,700.00	83.8%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	369,000.00	355,728.00	13,272.00	96.4%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00	22,000.00	50.0%
210807	Газрын төлбөр	66,000.00	35,700.00	30,300.00	54.1%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,879,000.00	1,879,000.00	-	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,879,000.00	1,879,000.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,927,300.00	41,135,210.00	792,090.00	98.1%
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,927,300.00	41,135,210.00	792,090.00	98.1%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,475,300.00	40,475,210.00	90.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,452,000.00	660,000.00	792,000.00	45.5%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82	75	7	91.5%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	76	71	5	93.4%
620003	Үйлчлэх ажилтан	5	3	2	60.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	82	75	7	91.5%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	77	72	5	93.5%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	3	2	60.0%

2.6 Аудит хийсэн 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,456,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,456,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	132,415,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,960,000.00
210401	Бичиг хэрэг	29,360,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,300,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,055,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,170,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,885,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,400.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	41,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,456,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,456,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	132,456,400.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 74,532.1 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Акталсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 67,491.2 мянган төгрөгөөр илүү тооцож хассаныг;
- Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй 3,600.0 мянган төгрөгийн орлогыг өөрийн орлогоор тайлагнасныг;
- Нийгмийн даатгалын сангаас олгосон 3,440.9 мянган төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардалд бүртгэж, үр дүнгийн тайлангийн зардлыг илүү илэрхийлснийг;

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НБББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 48,303.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 23,389.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 24,913.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 48,303.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,826.2 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Төсвийн хөрөнгөөр 22,663.5 мянган төгрөгийн бараа, материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй, шууд худалдан авах зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*", 10.12-т "*Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно*" заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авах зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Татан буугдсан байгууллагатай холбоотой, насжилт өндөртэй 726.3 мянган төгрөгийн авлагыг найдваргүй авлагаар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;*", 20.2.4-т "*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;*", 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*", Сангийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 6 дугаар бүлгийн 6.6. Байгууллага арилжааны ажил гүйлгээний үр дүнд бий болсон авлагын үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын нөөцийг байгуулахдаа өмнөх жилүүдийн туршлагад үндэслэн авлагын эргэн төлөлтөд нөлөөлж болох доорх хүчин зүйлсийг харгалзан хувь хэмжээг тогтооно: (в) төлбөр хариуцагч (хуулийн этгээд) татан буугдах, дампуурах боломж, эсхүл удирдлага, бүтэц өөрчлөгдөх нөхцөлүүд; (г) авлага нь төлөгдөх хуваарьт өдрөөс хойш 1 жилээс дээш хугацаанд хөдөлгөөн хийгдээгүй; (д) төлбөр хариуцагч гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх бусад тохиолдол, нөхцөлүүд, тэдгээрт байгууллагын зүгээс авах арга хэмжээ., 6.7. Шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төлөгдөх найдваргүй болсон авлагыг данснаас хасаж болно." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*", "*тохиолдсон байх*" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татан буугдсан байгууллагатай холбоотой авлагыг найдваргүй авлагад бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгөв.

3. Хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн, актлагдсан 25,778.2 мянган төгрөгийн хөрөнгийг тооллогын дүнд оруулж тоолсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "*жинхэнэ хэрэгжилтийн;*" 12 дугаар зүйлийн 12.1-т "*Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.*", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн

тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгөв.

3.2 Зөвлөмж

1. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр татварын улсын байцаагчийн сарын ажлын үр дүнгийн урамшуулалд 24,913.4 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “*хариуцлагатай байх.*”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.6-т “*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.*” 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*үнэн зөв байх*”, “*тохиолдсон бай*” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

2. Цалингийн баримтыг архивын нэгж болгож архивлаагүй байна. Энэ нь Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “*архивын баримт*” гэж *архивт байнга болон түр хугацаагаар хадгалагдаж байгаа бүх төрлийн баримтыг;*” 44 дүгээр зүйлийн 44.3-т “*Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлсний дараа байгууллагын удирдлагаар батлуулж, оны эхнээс мөрдөж ажиллана.*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн баримтыг, харилцах дансны баримтаас салгаж холбогдох хууль, журмын дагуу архивлаж хэвших.

3. Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Татварын Ерөнхий Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дугаар тушаалтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*үнэн зөв байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогчид өөр ажил хавсруулан ажиллуулахгүй байх, нягтлан бодох бүртгэлийн хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалын сангаас олгосон ХЧТАТ-ыг ерөнхий журналд цалингийн зардлын дансаар дамжуулсан гүйлгээ хийж Үр дүнгийн тайлангийн цалин зардлыг илүү илэрхийлсэн.	1	3,440.9	-	-	1	3,440.9	1	3,440.9	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй орлогыг орлогоор тайлагнасан	1	3,600.0	-	-	1	3,600.0	1	3,600.0	-	-	-	-
Акталсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг илүү тооцож хассан.	1	67,491.1			1	67,491.1	1	67,491.1				
Дүн	3	74,532.1	-	-	3	74,532.1	3	74,532.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн, 25,778.2 мянган төгрөгийн акталсан үндсэн хөрөнгийн дүнг тооллогын дүнд оруулж тоолсон.	1	0.0			1	0.0	1	0.0
Татан байгууллагатай холбоотой, насжилт өндөртэй авлагыг найдваргүй авлагаар бүртгээгүй байна.	1	726.3			1	726.3		
Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй, харьцуулалтын аргаар тендер	1	22,663.5			1	22,663.5		

зарлалгүйгээр бичиг хэргийн материалыг шууд худалдан авсан.								
Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байна.	1	0.0						
Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр ТУБ-ын үр дүнгийн урамшуулал олгосон.	1	24,913.4					1	24,913.4
Цалингийн баримтыг тусд нь архивын нэгж болгож хадгалаагүй байна.	1	0.0					1	0.0
Дүн	6	48,303.2	-	-	3	23,389.8	3	24,913.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 320,641.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, 5 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	1	320,641.2					1	320,641.2
Үндсэн үйл ажиллагааных нь зардлыг улсын төсвөөс баталж өгсөн байхад үндсэн чиг үүргээ хэрэгжүүлснийхээ төлөө орон нутгийн төсвөөс давхардуулан санхүүжилт авч зарцуулсан байна.	1	132,415.0			-	-	1	132,415.0
Дүн	2	453,056.2					2	453,056.2